

# ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

НИЙСЛЭЛ, ДҮҮРГҮҮДИЙН ЗДТГ

2017 ОНЫ 2 ДУГААР САРД

Нийслэл, дүүргийн нийт 10 Засаг даргын тамгын газар (ЗДТГ) Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хэрхэн хангаж байгаад иргэний нийгмийн байгууллагууд мониторинг хийж байна. Хуулиар ЗДТГ-уудын нийтэд ил болгох ёстой мэдээллээс зургааг нь сонгон авч 2017 оны 2 дугаар сарын туршид эдгээр мэдээллийг хэрхэн ил тод болгож байгааг ажиглав.

## АЖИГЛАЛТЫН ЕРӨНХИЙ ҮР ДҮН



Дүүргүүд 5 сая төгрөгөөс дээш дүнтэй худалдан авалт, гүйлгээний мэдээллээ бүрэн гүйцэд ил тод болгох байдал хангалтгүй байгаа ч өмнөх сартай харьцуулахад 1 дүүрэг нэмэгдэж 2-р сард нийт 3 дүүрэг 100 хувь нийтэлжээ.

Шилэн дансны тухай хуулийн дагуу нийслэл, дүүргүүдийн ЗДТГ 2017 оны 2 дугаар сард ил тод болгосон 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй худалдан авалт, гүйлгээний мэдээллийг Сангийн яамны Төрийн сангийн тухайн сарын дансны хуулгатай харьцуулж үзэв (Тайлбар 2–ыг үзнэ үү).




Тайлбар: 1 = 10%

### ЦАЛИНГААС БУСАД 5 САЯ ТӨГРӨГӨӨС ДЭЭШ ҮНИЙН ДҮН БҮХИЙ ОРЛОГО, ЗАРЛАГЫН МЭДЭЭЛЭЛ



Шилэн дансны тухай хуулийн 6.4.5-р заалтын дагуу ил тод болгох орлого, зарлагын гүйлгээг СБД хамгийн олныг буюу 32-ыг нийтэлжээ (Тайлбар 1-ийг үзнэ үү).

Тайлбар: 1 = 1 мэдээлэл



Зөвхөн гурван ЗДТГ цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээнд холбогдох шийдвэрийг нийтэлжээ.



Шилэн дансны тухай хуулийн 6.4.4-р заалтын дагуу ил болгох худалдан авалтын мэдээллийг зургаан ЗДТГ нийтэлжээ (Тайлбар 1-ийг үзнэ үү).

Хуулийн дагуу 1 дүгээр сарын 10-ны дотор нийтэд ил тод болгох ёстой 2017 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Налайх, Сүхбаатар дүүргийн ЗДТГ-ууд хугацаанд нь нийтэлжээ. Харин 2 дугаар сард Баянгол, Чингэлтэй дүүргийн ЗДТГ уг төлөвлөгөөг хугацаа хоцорч нийтэлсэн бол бусад дүүргийн ЗДТГ түүнийг ил болгоогүй хэвээр байна.

Нийслэл, дүүргийн ЗДТГ-ууд 2017 оны 2-р сарын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээгээ 3 дугаар сарын 8-ны дотор бүгд нээлттэй мэдээлжээ.

#### Дүн мэдээнд хамаарах тайлбар:

- 5 сая төгрөгөөс дээш дүнтэй худалдан авалт болон гүйлгээний тоог гаргахдаа ЗДТГ-ын шилэн дансанд нийтлэгдсэн мэдээллээс зөвхөн үүнд хамааралтайг түүвэрлэж авсан болно.
- Төрийн сангийн гүйлгээнээс ил тод болгосон хувийг үнэлэхдээ зөвхөн энэ оны 2 дугаар сард хамаарах 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт болон гүйлгээг тооцсон болно. Мөн 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий залруулга хийсэн гүйлгээг тоонд оруулсан болно.

АШИГЛАСАН МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ  
– Шилэн дансны нэгдсэн цахим хуудас  
– ЗДТГ-ын цахим хуудас

– ЗДТГ-ын мэдээллийн самбар  
– Сангийн яамны Төрийн сангийн дансны хуулга

Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд иргэний нийгмийн байгууллагууд мониторинг хийж дүнг сар бүр мэдээлж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг [www.forum.mn](http://www.forum.mn) цахим хуудаснаас үзнэ үү.